

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД ТАНАА

2017 оны 5 дугаар сарын 12

Санал хүргүүлэх тухай

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжихийн төлөө ажилладаг төрөл бүрийн салбарын иргэний нийгмийн байгууллага, эвсэл, сүлжээ 2012 оноос эхэлсэн Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг дэмжиж, энэ хүрээнд шинээр боловсруулж буй хууль тогтоомжийн төсөлд санал бодлоо тусгуулахаар идэвх санаачлагатай ажиллаж ирсэн билээ. Бид 2016 оны намраас “5 хуулийн эвсэл” нэрийн доор эвлэлдэн нэгдэж, хууль тогтоомжийн төсөлд өөрсдийн дуу хоолойгоо нэмэрлэхээр ажиллаж байна.

Бидний зорилго нь эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн амин сүнс болсон багц хуулиудад тусгагдсан хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр гарсан ахиц дэвшлийн талаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, хуулийн төслийн шинэчилсэн найруулга боловсруулах, хэлэлцэх үйл явцад бодитойгоор оролцож, санал зөвлөмжөө тусгуулах явдал болно.

Монгол Улсын Их Хурлын энэ хаврын чуулганаар хэлэлцэж буй Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулга нь хүний эрх, эрх чөлөөнд халдах журмыг тогтоож өгдөг хуулиуд тул батлах үйл явц олон талын оролцоо, зөвшилцөлд тулгуурлах, хүний эрхийн суурь зарчмыг ягштал баримтлахыг шаарддаг билээ. Гэтэл эдгээр хуулийн төсөл цахим хуудсанд тавигдсанаас хойш зарчмын олон өөрчлөлт хийгдэхээр яригдаж байгаа ч төсөлд орж буй нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээлэл хаалттай, олон талын оролцоог хангах хэлэлцүүлэг үгүйлэгдэж байгааг доорх баримт нотлон харуулж байна. Тухайлбал:

- Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулсан эдгээр 4 хуулийн төслийн танилцуулгад хууль санаачлагч олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн эсэх

тухай огт дурдаагүй бөгөөд зөвхөн “иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн санал байхгүй болно”, “олон нийтийн санал зөвлөмжид үндэслэсэн” гэжээ.

- УИХ-аар хэлэлцэгдэж байгаа төслүүд өмнө нь батлагдсан эсхүл буцаагдсан хувилбараас үзэл баримтлал, зарчим, агуулгын хувьд ялгаатай эсэх, хэрхэн сайжруулсан болох, оруулж буй нэмэлт өөрчлөлтийн үндэслэл, шалтгааны талаарх мэдээлэл нээлттэй биш байна.
- Төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхэд бэлтгэх чиг үүрэгтэй дэд ажлын хэсэгт хүний эрхийн төлөө ажилладаг ТББ-уудын төлөөллийг оролцуулаагүй.

Улсын Их Хурал эдгээр хуулийг 2017 оны 7-р сарын 1-нээс хэрэгжиж эхлэх ёстой гэх шалтгаанаар олон талын оролцоог хангахгүйгээр яаравчлан батлах нь хүний эрхэд халдах журмыг тогтоодог хуулиудын чанарт нөлөөлж болзошгүй байна.

Энэ бүхэн нь Улсын Их Хурал хууль тогтоох үйл ажиллагаагаа нээлттэй, ил тод, хариуцлагатай, иргэдэд хүртээмжтэй, асуудлыг тал бүрээс нь хэлэлцэх зарчмаар хэрэгжүүлэхгүй байгаагийн илрэл гэж үзэж байна.

Иймд бид доорхи **САНАЛ**ыг хүргүүлж байна. Үүнд:


1. Улсын Их Хурал хууль тогтоох чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Хууль тогтоомжийн тухай хуулийг нэг мөр мөрдөж, хууль санаачлагч тухайн хуулийн төслийг боловсруулах явцад олон нийтийн оролцоог хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, судалгаа, шинжилгээнд үндэслэх, нээлттэй, ил тод байх зэрэг шаардлагыг хангасан эсэхийг сайтар нягтлах, зөрчигдсөн тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах;
2. Засгийн газраас өргөн барьсан дээрх хуулийн төсөлд бодлого, зарчмын шинжтэй ямар өөрчлөлтүүд оруулсан талаарх мэдээллийг тайлбарын хамт олон нийтэд хүргэх;
3. Хуулийн төслүүдийг УИХ-аар хэлэлцүүлэхэд бэлтгэх Дэд ажлын хэсгүүдэд хүний эрхийн ТББ-ын төлөөллийг оролцуулах зэрэг болно.

Бид энэхүү саналаа олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд танилцуулах болно.



Хуулбарыг: УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга, УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны дарга, УИХ дах намын бүлгийн дарга нарт


САНАЛД НЭГДСЭН ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД:

№	Байгууллага, түүний гишүүд:	Төлөөлсөн гарын үсэг, тэмдэг:
1	“БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ” ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ ЭВСЭЛ /гишүүн байгууллага 23/	
2	МОНФЕМНЕТ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ /гишүүн байгууллага 25/	
3	МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН	

4	ХҮНИЙ НАЙМААНЫ ЭСРЭГ ТББ-УУДЫН СҮЛЖЭЭ /гишүүн байгууллага 9/	
5	ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ /гишүүн байгууллага 16/	
	ХҮНИЙ ЭРХИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ФОРУМЫН ГИШҮҮД:	
7	ХҮНИЙ ЭРХ, ХӨГЖИЛ ТӨВ	
8	ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ТӨВ	
9	НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ	
10	ХҮЙСИЙН ТЭГШ ЭРХИЙН ТӨВ	

11	ҮНДСЭН УРТРАГ	
12	БУЛАГ ШАНД, ГОЛ МӨРНИЙ ЭХИЙГ ХАМГААЛАХ САН	
13	ХИЛ ХЯЗГААРГҮЙ АЛХАМ	
14	ИХ БАГА БАЯНШАРГА	
15	ТӨР ИРГЭН ТҮНШЛЭЛ	
16	ЭВТ САЙН ХӨРШ САН	

17	ТУВА ЭЭЖ	
18	ЗАХИРГААНЫ ШИНЭ САНААЧЛАГА	
19	ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨӨХ ЭМЭГТЭЙЧҮҮД	
20	БҮСГҮЙЧҮҮД ХХІ ЗУУН ТӨВ	
21	ОЮУ ТОЛГОЙН ХЯНАЛТ	
22	ХИЛ ХЯЗГААРГҮЙ ГОЛ МӨРӨН ЭВСЭЛ	

23	СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛ ТӨВ	
24	Нийгмийн Звснл Энхлэлтүүд Харамсаа	
25	Сэтгэлзүйн мэдэрэлчс ТББ	
26	Хэрэглэлийн эрхийг хамгаалах "Заша өвс" нүтбб.	
27	Мекголын эрхтэйчүүд дунд холбоо, ТББ	
28	Саянаа Сайн Сайхны Ашигтэмэл	

Энэ бичгийн 5%-ийг хаягийн дагуу хүлээн авлаа

Төрийн ордны шуудангийн ажилтан

2/15 1620'

П. Баярчуу

Баярчуу

Нэр

(гарын үсэг)

Хүлээлгэн өгсөн

С.Цэндбаатар

С.Цэндбаатар